



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/36

Баян-Адарга сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэхь заалт, Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч С.Пүрэвцэрэн, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Гимаа, Хүнс, Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Энх-Ариунаа, Төсөв, Төрийн сангийн мэргэжилтэн Д.Дуламсүрэн нарыг төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамруулсугай.

2.Албан хаагчдын сургалтын зардалд 800,000 (Найман зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

3.Дээрх зардлыг мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Б.Агиймаа)-д зөвшөөрсүгэй.

~~ЗАСАГ ДАРГА~~ ~~О.ЛХАГВАДОРЖ~~

